



ГАЗРЫН ХАРИЛЦАА, БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН ГАЗРЫН 2022 ОНЫ 02 ДУГААР САРД ХИЙСЭН АЖЛЫН ТАЙЛАН

2022.02.24

Дархан-Уул аймаг

1. ГАЗРЫН ХАРИЛЦААНЫ ЧИГЛЭЛЭЭР ХИЙСЭН АЖЛЫН ТАЙЛАН

Газрын хянан баталгаа, мониторингийн чиглэлээр:

- ✓ Газрын төлөв байдал, чанарын захиалгат хянан баталгааны 5, өмнө нь хянаж буцаасан 7 тайланг баталгаажуулсан.
- ✓ Дархан-Уул аймгийн Шарын гол сумын ЗДТГазын захиалгаар хийсэн 47 айлын шинээр өмчлөх газрын хянан баталгааны тайланг хянаж зөрүүтэй мэдээллийг засуулж байнгын шинжээчээр баталгаажуулан дүгнэлтийг хүргүүлсэн.

Газрын кадастр, бүртгэл чиглэлээр:

- ✓ Газар эзэмших эрхийн гэрээ гэрчилгээ шинэчлэх хүсэлтэй 7 иргэний газарт дундын мэдээллийн сангаар дамжуулан Э дугаар авч газар эзэмших эрхийн цахим гэрээ гэрчилгээг үүсгэсэн.
- ✓ Газрын эрх зүйн харилцааг хянан шийдвэрлэх хурлаар:
 1. Газар эзэмших эрхийн гэрчилгээний угацаа сунгах-2
 2. Талбайн хэмжээ өөрчлөх-1
 3. Газар эзэмших эрх шилжих-16
 4. Зориулалт өөрчлөх-1 иргэний

Геодези, зураг зүйн, кадастрын чиглэлээр:

Геодези, зураг зүйн, кадастрын зураглалын ажил үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөлтэй “Ёлт сүрвэй” ХХК-ний хийж гүйцэтгэсэн “Баян брижд” ХХК 216-н айлын орон сууцны барилгын улаан шугам ажлыг шалгаж хүлээн авсан.

Хаягийн зургийн дагуу **12** иргэн, **3** аж ахуйн нэгжийн эзэмшлийн газар, үл хөдлөх эд хөрөнгөд хаяг дугаар олгосон.

Шинээр үл хөдлөх эд хөрөнгийн гэрчилгээ авахаар /хувийн сууц, гараж, барилга байгууламж/ хэмжилт хийлгэсэн **6** иргэн, **1** аж ахуйн нэгжийн материалыг хүлээн авч мэдээлийн санд оруулж кадастрын зураг гаргасан.

Өмчлөх эрхээ бусдад шилжүүлэх хүсэлтээ цахимаар ирүүлсэн **12** иргэний материалыг хянаж өмчлөх эрхийг шилжүүлсэн.

Шуудангийн нэгдсэн кодын мэдээллийн санд шинэчлэлт, баяжуулалт хийх ажлын хүрээнд Дархан сумын баг, хорооны зохион байгуулалтанд өөрчлөлт орсон эсэхийг харуулсан хилийн цэсийн зураг, иргэн, аж ахуйн нэгжийн эзэмшил ашиглалтанд байгаа газар болон үл хөдлөх эд хөрөнгийн байршлын зургийг Монгол Улсын Харилцаа Холбооны зохицуулах хороонд хүргүүлсэн.



Зургийг amgalan.ts@crc.gov.mn цахим хаягаар явуулсан.

Цагдаагийн газрын мөрдөн байцаах тасагт шалгагдаж байгаа гэмт хэргийн бүртгэлийн 129 дугаартай гомдол мэдээлэлд дурдагдсан газрын байршлыг харуулсан зургийг гаргаж хүргүүлсэн. Уг газар нь Сэлэнгэ аймгийн Сайхан сумын нутаг дэвсгэрт байрлаж байгаа нь өгөгдсөн солбицол болон хилийн цэсийн зургаар баталгаажиж байна.

Шуудан хүргэлтийн ажилчид зориулан Дархан сумын 15 дугаар багийн 1-10-р хэсгийн хаягийн зургийг авах хүсэлтийг ирүүлсэн “Монгол шуудан” ХХК-ны хүсэлтийн дагуу 1-10-р хэсгийн хаягийн 13 ширхэг зургийг А4 форматаар / шинэ, хуучин / хэвлэн хүргүүлсэн.

БОАЖЯ-ны төрийн нарийн бичгийн даргын 2019 оны А/489 дугаар тушаалаар “Шарын гол сумийн төвийн хүн амын унд-ахуйн төвлөрсөн ус хангамжийн” эрүүл ахуйн хамгаалалтын бүс тогтоосон солбицол, Шарын гол сумын ИТХ-ын 2021 оны №23 дугаар тогтоолоор орон нутгийн тусгай хэрэгцээнд авсан газрын солбицолуудыг давхцуулан шалгаж байршил болон давхцалыг харуулсан зураг 4 ширхэг зургийн хамт Шарын гол сумын Засаг даргад албан бичгээр хүргүүлсэн.



Газрын төлбөрийн талаар:

✚ 2022 оны газрын төлбөрийн ногдол, нэхэмжлэл үүсгэх ажлыг зохион байгуулж ажиллаа. Аймгийн хэмжээнд 8390 хүчинтэй гэрээний 8315 гэрээнд төлбөрийн ногдол үүсгэж, гүйцэтгэл 99.1 хувьтай явж байна.

№	Сумын нэр	Хүчинтэй гэрээ	Гэрээний төлбөр	Ногдуулсан гэрээний тоо	Ногдуулалтаар	Нэхэмжлэлийн тоо	Нэхэмжлэл үүсгэсэн дүн
1	Дархан	4623	1,193,441,136	4579	1,177,388,523	5211	1,115,108,840
2	Орхон	749	37,939,615	729	37,182,455	657	27,901,219
3	Хонгор	2710	327,938,305	2717	329,778,964	2793	285,966,088



4	Шарын гол	308	104,577,312	290	95,200,397	271	94,516,110
Аймгийн хэмжээнд		8390	1,663,896,368	8,315	1,639,550,339	8,932	1,523,492,257

✚ Аймгийн хэмжээнд 8315 гэрээнд ногдол үүсгэснээс 7638 гэрээнд 8932 нэхэмжлэлээр 1.5 тэрбум төгрөгийн нэхэмжлэл үүсгэж, гүйцэтгэл 91.8 хувьтай явж байна.

№	Сумын нэр	Ногдуулсан гэрээний тоо	Нэхэмжлэл үүсээгүй гэрээний тоо	Мөнгөн дүн /төгрөг/ /Шинээр үүсгэх/	Нэхэмжлэл үүссэн гэрээний тоо
1	Дархан	4579	379	63,846,301.00	4200
2	Орхон	729	123	7,934,176.00	606
3	Хонгор	2717	150	34,776,002.00	2567
4	Шарын гол	290	25	582,153.00	265
Аймгийн хэмжээнд		8,315	677	107,138,632.00	7638

2021 оны газрын төлбөрийн орлогын төлөвлөгөө

№	Сумын нэр	Орлогын төлөвлөгөө	Нэхэмжлэл үүссэн мөнгөн дүн /төгрөг/	Хувь	2022.02.14 Илүү, Дутуу төлбөр /төгрөг/
1	Дархан	1,020,500,000.00	1,115,108,840.00	109.3	(94,608,840.00)
2	Орхон	33,500,000.00	27,901,219.00	83.3	5,598,781.00
3	Хонгор	361,000,000.00	285,966,088.00	79.2	75,033,912.00
4	Шарын гол	85,000,000.00	94,516,110.00	111.2	(9,516,110.00)
Аймгийн хэмжээнд		1,500,000,000.00	1,523,492,257.00	101.6	(23,492,257.00)

✚ 2022 онд зохион байгуулах дуудлага худалдааны нэгж талбарын тоо, талбайн хэмжээ, орлогын төлөвлөгөөг гаргасан. 2022 онд нийт 36 нэгж талбарт газрын дуудлага худалдаа зохион байгуулах төлөвлөгөөтэй байна.

2022.02.11

№	Сумын нэр	Төлөвлөсөн нэгж талбар	Талбайн хэмжээ /га/	Дуудлага худалдааны анхны үнэ
1	Дархан	5	2.3	495,230,400.00
2	Орхон	5	2.9	28,528,000.00
3	Хонгор	22	126.8	924,814,600.00
4	Шарын гол	4	0.2	2,013,000.00
Нийт		36	132.1	1,450,586,000.00

2022 онд зохион байгуулах төсөл сонгон шалгаруулалтын нэгж талбарын тоо, талбайн хэмжээ, орлогын төлөвлөгөө

№	Сумын нэр	Төлөвлөсөн нэгж талбар	Талбайн хэмжээ /га/	Дуудлага худалдааны анхны үнэ
1	Дархан	1	1550	
Нийт		1	1550	-



Шарын гол сум

Иргэн, хуулийн этгээдээс ирүүлсэн 18 өргөдөл хүсэлтийн дагуу Сумын Засаг даргын захирамж гаргуулж шийдвэрлэсэн. /Эзэмшиж буй газраа өмчлөх 2, эзэмшиж буй газраа бусдад шилжүүлэх, газар өмчлөх эрх дуусгавар болгох 1, өмчлөх газрын талбайн хэмжээг өөрчлөх 11/.

Кадастр бүртгэл: Э дугаар авах хүсэлтэй 1 иргэний мэдээллийг газрын мэдээллийн санд оруулж, гэрээ байгуулсан. Газар өмчилж авсан 11 иргэнд кадастрын зургаар үйлчилсэн.

2022 онд зохион байгуулагдах газрын дуудлага худалдааны судалгааг гаргасан.

Газрын төлбөр: 2020, 2021 оны газрын төлбөрөө төлөөгүй иргэн, хуулийн этгээдийн судалгааг гарган татварын улсын байцаагчид хүргүүлсэн. Газрын мэдээллийн санд бүртгэлтэй 308 гэрээнээс 290 гэрээнд төлбөрийн ногдуулалт хийсэн. 271 гэрээнд 94.5 сая төгрөгийн нэхэмжлэл үүсгэсэн, 25 гэрээ нь хөрөнгийн бүртгэл үүсээгүй болон татварт бүртгэлгүй байна.

Бичил уурхайн зориулалтаар тусгай хэрэгцээнд авсан газрын судалгааг гаргасан. Орон нутгийн тусгай хамгаалалтад авсан Буянтын хөндийн төвлөрсөн ус хангамжийн эх үүсвэрийг тусгай хэрэгцээнд авсантай холбоотой нотлох баримтыг албан тоотоор шүүхэд хүргүүлсэн.

Орхон сум

Сумын засаг даргын захирамжаар нийт 20 иргэний хүсэлтийг хүлээн авч шийдвэрлэсэн. Үүнээс газар эзэмшүүлэх 2, хугацаа сунгах 2, өмчилсөн газрын талбайн хэмжээ өөрчлөх 5, эзэмшил газрын талбайн хэмжээ өөрчлөх 3, газар эзэмших эрхийг бусдад шилжүүлэх 7, хүчингүй болгох 1, хүсэлт хүлээн авч шийдвэрлэсэн байна. Газар зохион байгуулалтын цахим системд бүртгэлгүй Орхон сумын 1, 2-р багийн нийт 154 иргэнтэй холбогдож нөхөн бүрдүүлэлтийн ажилтай холбоотой мэдээллийг хүргэсэн үүнээс 38 иргэн ирж нөхөн бүрдүүлэлтэнд хамрагдсан байна.

Кадастр бүртгэл: Газар эзэмших эрхийн гэрээ гэрчилгээ шинэчлэх хүсэлтэй 10 иргэний газарт дундын мэдээллийн сангаар дамжуулан Э дугаар авч газар эзэмших эрхийн гэрчилгээг бичиж гэрээ байгуулсан. Гэр бүлийн хэрэгцээний зориулалтаар газар өмчилж авсан иргэний худалдах худалдан авах гэрээ 9, кадастрын зургаар 15 иргэнд үйлчилсэн. Газрын кадастрын мэдээллийн санд нөхөн бүрдүүлэлтийн ажлаар цахим системд оруулахаар 115 иргэний материалыг бүрдүүлсэн байна

Газрын төлбөр: Орхон сумын татварын улсын байцаагчид 2020, 2021 оны газрын төлбөр төлөөгүй иргэн хуулийн этгээдийн судалгааг гаргаж хүлээлгэн өгсөн. Мөн газрын мэдээллийн санд бүртгэлтэй 749 гэрээнээс 729 гэрээнд газрын төлбөрийн ногдуулалт хийж, 606 гэрээнд 29.2 сая төгрөгийн нэхэмжлэл үүсгэсэн байна. Нэхэмжлэл үүсээгүй 123 гэрээ нь хөрөнгийн бүртгэл үүсээгүй болон татварт бүртгэлгүй байна.

Хонгор сум

Газар эзэмших эрхийн гэрчилгээг бусдад шилжүүлэх тухай 8, Газар эзэмших эрхийн гэрчилгээний хугацааг сунгах тухай 2, Худалдах худалдан авах гэрээгээр өмчилсөн газрынхаа эрхийг шилжүүлэх тухай 2 нийт 12 өргөдөл хүсэлтийг Засаг даргад танилцуулан захирамжийн төсөл боловсруулан шийдвэр гаргуулсан.



Нэгж талбарын хувийн хэргийн хавтас нийт 250 ширхэгийн тайлан гаргаж ГХБХБГ-ын няравтай тооцоо нийлж тайланг хүргүүлсэн.

Кадастр бүртгэл: Сумын засаг даргын 2022 оны 02 дугаар сарын 17,18,19 тоот шийдвэрийн дагуу нийт 12 иргэн, аж ахуй нэгж байгууллагатай гэрээ байгуулж дээрх шийдвэрийн биелэлтийг 100% хангаж ажилласан.

Газрын төлбөр: Газрын мэдээллийн вэб системээс хүчинтэй гэрээ 2712 гэрээнд 2022 оны газрын төлбөр 327,9 сая төгрөгийн ногдуулалтыг үүсгэсэн. 2022 оны 02 дугаарын 21-ний байдлаар нийт 13.3 сая төгрөгийг төвлөрүүлэн ажилласан байна. Гэрээнд ногдуулалт үүсээгүй 143 гэрээг ногдуулалт үүгэхээр мөн татварт бүртгэлгүй гэх судалгааг гарган ажиллаж байна. Мэдээллийн санд байхгүй өвөлжөө, хаваржаа г.мэт газруудын судалгааг гаргаж харъяа багийн Засаг дарга, Хөдөө аж ахуйн мэргэжилтэн нарт хүргүүлсэн, зуслан, бусад газрын хувийн хэргийг шинэчлэн ажиллаж байна.

2. БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН ЧИГЛЭЛЭЭР ХИЙСЭН АЖЛЫН ТАЙЛАН

Барилга материалын үйлдвэрлэл, хөгжүүлэлтийн хүрээнд:

Дархан-Уул аймагт Барилгын материалын үйлдвэрлэл эрхэлж байгаа 28 ААНБ-уудаас Барилга, Хот байгуулалтын сайд, Үндэсний статистикийн хорооны даргын хамтарсан 2019.12.18-ны өдрийн 206,А/184 тоот тушаалаар батлагдсан маягтын дагуу 2021 оны мэдээг хүлээн авсан. 2022 оны 2 сарын 08-ны байдлаар 23 байгууллага мэдээ ирүүлсэн байна.

Гялалзах гэрэл ХХК, Их торгоны зам ХХК, Мэжик ньу ворлд ХХК-ууд мэдээ ирүүлээгүй болно. Гантиг өргөө ХХК, Чуань Мон арматур ХХК-иуд 2021 онд үйлдвэрлэл явуулаагүй тухай албан тоот ирүүлсэн. Мэдээг нэгтгэн 2022.02.09-ний 67 албан тоотоор Барилга, хот байгуулалтын яам, Барилгын хөгжлийн төв, Барилгын материал үйлдвэрлэгчдийн холбоонд хүргүүлээ.



Дархан-Уул аймагт Барилгын материалын үйлдвэрлэл эрхэлж байгаа 28 ААНБ-уудаас Барилга, Хот байгуулалтын сайд, Үндэсний статистикийн хорооны даргын хамтарсан 2019.12.18-ны өдрийн 206,А/184 тоот тушаалаар батлагдсан маягтын дагуу 2021 оны мэдээг хүлээн авсан. 2022 оны 2 сарын 08-ны байдлаар 23 байгууллага мэдээ ирүүлсэн байна.

Гялалзах гэрэл ХХК, Их торгоны зам ХХК, Мэжик ньу ворлд ХХК-иуд мэдээ ирүүлээгүй болно. Харин Гантиг өргөө ХХК, Чуань Мон арматур ХХК-иуд 2021 онд үйлдвэрлэл явуулаагүй тухай албан тоот ирүүлсэн.

Мэдээг нэгтгэн хүргүүлээ. Хавсралт 2-хуудастай.



№	Байгууллагын нэр	Хажуу нэр	БТӨ/Сая	Үйлдвэрлэл үзэгч, худал, бусад ажлаагаа	Ажилбарны дугаар	Гайзмет үзэгч үйлдвэрлэл/бизнес	Бетт ажлаа	Н	Тайлбар
1	Дархан-Уул аймагт Барилгын материалын үйлдвэрлэл эрхэлж байгаа 28 ААНБ-уудаас Барилга, Хот байгуулалтын сайд, Үндэсний статистикийн хорооны даргын хамтарсан 2019.12.18-ны өдрийн 206,А/184 тоот тушаалаар батлагдсан маягтын дагуу 2021 оны мэдээг хүлээн авсан. 2022 оны 2 сарын 08-ны байдлаар 23 байгууллага мэдээ ирүүлсэн байна.								
2	Гялалзах гэрэл ХХК, Их торгоны зам ХХК, Мэжик ньу ворлд ХХК-иуд мэдээ ирүүлээгүй болно. Харин Гантиг өргөө ХХК, Чуань Мон арматур ХХК-иуд 2021 онд үйлдвэрлэл явуулаагүй тухай албан тоот ирүүлсэн.								
3	Мэдээг нэгтгэн хүргүүлээ. Хавсралт 2-хуудастай.								
4	Барилга, хот байгуулалтын яам, Барилгын хөгжлийн төв, Барилгын материал үйлдвэрлэгчдийн холбоонд хүргүүлээ.								



Барилгын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөлтэй аж ахуйн нэгж, байгууллагууд үйл ажиллагааны тайлан мэдээг Барилга, хот байгуулалтын сайд, Үндэсний статистикийн хорооны даргын хамтарсан 2019 оны 206, А/184 дүгээр тушаалаар шинэчлэн баталсан маягт, маягт нөхөх зааврын дагуу хуулийн хугацаанд /2022.02.21-ны дотор/ Барилгын нэгдсэн мэдээллийн систем-д <https://mcis.gov.mn/> тайлагнах тухай сануулж утсаар мэдэгдэв.

Барилгын хяналт шалгалтын хүрээнд:

Монгол Улсын Засгийн Газар болон Бүгд Найрамдах Австри Улсын Засгийн Газар хооронд байгуулсан “Санхүүгийн хамтын ажиллагааны хэлэлцээр”-ийн хүрээнд хэрэгжиж буй “Дэд бүтцийн хөгжил – Баянзүрх, Дархан, Сэлэнгэ” гэр хорооллын гудамжны гэрэлтүүлгийн төсөл хүрээнд Хонгор сумын салхит өртөөнд хийгдсэн 111 ширхэг гэрэлтүүлэгийг ашиглалтад оруулах барилгын техникийн бичиг баримтыг хянаж холбогдох заавар зөвлөгөөг өгсөн.

Олон Улсын Жайка байгууллагатай хамтран Барилгын салбарын “Аюулын дүн шинжилгээ хийх Япон маягийн тэргүүн туршлага” сэдэвт ХАБЭА сургалт Дарханд зохион байгуулах талаар зөвшилцөж 2022.02.25-нд хийхээр болсон.

Засгийн газрын 212-р тогтоолын дагуу 2 гадна цахилгааны шугамын ажилд ашиглалтад оруулах комиссыг зохион байгуулж ажилласан. Үүнд:

- Дархан сум, 13-р баг, “Эрд хул” ХХК-ний ШТС агуулах
- Дархан сум, 13-р баг, “Бурхант эко асфальт” ХХК-ний автозамын бетон асфальтны үйлдвэр

Засгийн газрын 2009 оны 157-р тогтоолоор батлагдсан “Газар хөдлөлтийн гамшгийн эрсдэлийг бууруулах үндэсний хөтөлбөр”-ийн хэрэгжилтийн Аймгийн ОБГазарт хүргүүлсэн.

Инженер, дэд бүтцийн хүрээнд:

Дархан сумын 15-р баг Хабитат чиглэлийн дулааны шугамын 2-р хэлхээний УДДТ-ийн байршил тогтоож газрын захирамжийн хуралд танилцуулсан. Дархан сумын 3-р багт барихаар төлөвлөж буй Мэдээллийн төвийн барилга, 8-р багийн багийн төвийн барилгын инженерийн шугам сүлжээний зураг төслийг зөвшилцсөн.

Засгийн газрын 212-р тогтоолын дагуу 2 гадна цахилгааны шугамыг ашиглалтад комиссыг зохион байгуулж ажилласан. Үүнд: Хонгор сумын зулзагын голд Сая сая болор ХХК, Хонгор сумын зулзагын голд Иргэн Б.Банзрагчийн амралтын газрын цахилгааны шугам

2022 онд хийгдэхээр төлөвлөгдөж байгаа Залуус хороолол 1, Залуус хороолол 2-ын инженерийн шугам сүлжээний трассын зураг, материалын түүврийг гаргаж ХОХБТХ-т хүргүүлсэн.

Хабитат чиглэлийн инженерийн шугам сүлжээний 2 ээлжийн ажлын УДДТ-ийн байршилуудыг тодорхойлох, шугамын трассыг ерөнхий зураг төслийг гүйцэтгэсэн.

Хот байгуулалтын кадастр, зураг төслийн хүрээнд:

- ✓ Цахимаар архитектур төлөвлөлтийн даалгавар 2 боловсруулан батлуулсан.
- ✓ Мод тарих 16 байршлын хашаажуулах хэсгийн тооцоог боловсруулсан.
- ✓ “Ногоон Дархан-2032” хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын хуралд оролцсон




- ✓ Мэдээл холбооны Дархан дэд төвийн барилгын ажлын зураг хянасан.

3. ЗАХИРГАА, ДОТООД АЖИЛ:

Захиргаа, хүний нөөц

Сургалт:

- ✚ 2022 онд шинээр томилогдсон 2 албан хаагч нар МУ-ын Засгийн газрын хэрэг эрхлэх газрын сайтнаас <https://training-mongolia.thinkific.com/courses/rbm> “Үр дүнд суурилсан бодлого төлөвлөлт, хяналт-шинжилгээ, үнэлгээ” цахим сургалтад хамрагдаж байна.
- ✚ Нөхөн бүрдүүлэлтийн ажлын хүрээнд аймгийн ГХБХБГ-аас зохион байгуулсан сургалтанд 4 сумын даамлууд хамрагдсан. Мөн дээрх ажлын хүрээнд ГХБХБГ-аас бэлдсэн шторкийг сум, багийн цахим сайтанд байршуулсан.
- ✚ АТГ-аас сургалтын төлөвлөгөөний дагуу цахимаар 2022 оны 02 дугаар сарын 22-нд удирдлагуудад зориулсан цахим сургалтдад хэлтсийн дарга, ахлах, хүний нөөцүүд хамрагдсан, дараа өдөр нь 23-нд “zoom”-р зохион байгуулагдсан давтан сургалтад нийт 12 албан хаагчдыг хамруулсан.
- ✚ “ГХБХБГ-ын 2022 оны Авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөө”-г газрын даргаар 2022 оны 02 дугаар сарын 07-нд батлуулж, албан хаагчдад танилцуулсан.
- ✚ ХААИС-ын Агроэкологи бизнесийн сургуулиас 2022/2/16-ны өдрийн №1/18 албан бичгээр Мэргэжлийн хөтөлбөрийн шинэчлэн сайжруулах зорилгоор ажил олгогчийн төлөөлж бакалаврын сургалтын төлөвлөгөөнд санал хүргүүлэх талаар тус байгууллагын мэргэжилтнүүдээс саналыг авч хүргүүлхээр ажиллаж байна.



Шүүхийн мэдээлэл:

- ✚ “Дархан Ти Ви” ХХК-ын нэхэмжлэлд хариуцагчаар Аймгийн Засаг даргад холбогдох захиргааны хэргийг 2022/02/10-ны өдрийн Дархан-Уул аймгийн анхан шатны шүүх хуралдаанаар Дугаар 114/ШШ2022/0002 шийдвэрээр Нэхэмжлэлийн шаардлагыг хэрэгсэхгүй болгож шийдвэрлэсэн.
- ✚ “Бадрал Өргөө” –ний Дархан-Уул аймгийн Захиргааны хэргийн анхан шатны шүүхэд нэхэмжлэл гаргасны дагуу тус шүүхэд нэхэмжлэлтэй холбогдуулан нотлох баримтыг хуулбарлан №80 албан тоотоор хүргүүлсэн.

Хүний нөөц:

- ✚ Төрийн албаны тухай хуулийн дагуу Дэс түшмэлийн Зэрэг дэвийн шаардлага хангасан 4 албан хаагчдын материалыг ТАСЗөвлөлд 2022 оны 02 дугаар сарын 22-ны өдрийн №74, 88 албан тоотоор хүргүүлсэн.
- ✚ 2017 онд газрын даргаар батлуулсан “Байгууллагын дотоод журам”-ыг хөдөлмөрийн хууль шинэчлэгдсэнтэй холбогдуулж шинэчлэн батлуулхаар саналыг авч байна.



- ✚ Байгууллагын ёс зүйн зөвлөлийн бүрэлдэхүүнийг газрын даргын 2022/02/17 тушаалаар шинэчлэн батлуулсан. Үйл ажиллагааны төлөвлөгөөг 3 зорилт, 15 арга хэмжээ хэрэгжүүлхээр тусгасан.

Газрын хуралдаанд оруулсан өргөдөл, хүсэлт:


- ✚ Тахько ХК-д 2022/01/13-ны өдөр хүргүүлсэн албан тоотын хариуг 2022/01/31-нд манайд ирүүлсний дагуу газрын төлбөрийн асуудлыг судлан боловсруулж байна.
- ✚ Газрын эрх зүйн харилцааны хуралдаанд 9 албан хаагчид оролцож, иргэд, хуулийн этгээдээс газрын эрх шилжүүлэх, хугацаа сунгах, эрхийг хүчингүй болгох, шинээр олгох, талбайн хэмжээг өөрчлөх зориулалт өөрчлөх зэргээр нийт 90 өргөдөл, хүсэлт ирүүлснийг хуваарийн дагуу хэлэлцэж, аймаг, сумын Засаг даргын захирамжын төслийг боловсруулж байна.

ЭБАТ:

- ✚ Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын 4 албан хаагчдын 2021 оны ХАСХОМ-ийн тайланг аймгийн ХЭЗХэлтэсд 2022 оны 02 дугаар сарын 21-ний өдрийн №81 албан тоотой хүргүүлсэн. ЭБАТ-наар томилогдсон Б.Золбаясахын нэмэгдэлд өөрчлөлт оруулах газрын даргын Б/09 тушаалыг гаргаж ХЭЗХэлтэст хүргүүллээ.

Үүрэг даалгавар:

- ✚ 2022 оны 02 дугаар сарын 07-ны өдрийн шуурхай хурлаас өгсөн үүрэг даалгаврын биелэлтийг хүргүүлсэн.
- ✚ 2022 оны 02 дугаар сарын 01-06-ны өдөр байгууллагын хариуцлагатай жижүүрийн хуваарийг батлуулж, албан хаагчид мэдээг аймгийн хариуцлагатай жижүүрт хүргүүлж ажилласан.



- ✚ “Эрсдэлгүй хот” аяны хүрээнд 2022 оны 02 дугаар сарын 12-ны Бямба гарагийн өдрийг Дархан даяар цас мөсний цэвэрлэгээг зохион байгуулхаар төлөвлөсний дагуу тус байгууллагаас 15 албан хаагч нар оролцож хуваарьт газар болох 1-р Еотонгоос Монгол алтын зам хүртэлх авто болон явган хүний зам, 3-р Еотонгоос 10-р байрны араар ХХБанкны буудал хүртэлх явган зам хүртэлх зайтай газрын цас цэвэрлэгээний ажлыг хийсэн.

Баг	Байршил	Ажил гүйцэтгэсэн огноо	Оролцсон хүний тоо	Цэвэрлэсэн талбайн хэмжээ /м2/
8 дугаар баг	1-р зурагт: 3-р Еотонгоос 10-р байрны араар ХХБанкны буудал хүртэлх явган зам 2 дугаар зурагт: 1-р Еотонгоос Монгол алтын зам хүртэлх авто болон явган хүний зам,	2022/02/12	15	Байршил:1 153.47 метр Байршил:2 594.53 метр Нийт урт 747.99 метр Нийт талбай 4199.25 м2

✚ Байршил: 1



Байршил:2




Мэдээлэл технологийн чиглэлээр:

Байгууллагын цахим хуудсан дээр Нөхөн бүрдүүлэлтийн ажил хийгдэж буй талаарх мэдээлэл, Барилгын салбарын ХАБ-ын сургалтын зар мэдээллийг байрлуулав.

Байгууллагын Facebook цагаан сарын мэндчилгээний постер, Нөхөн бүрдүүлэлтийн ажил хийгдэж буй талаарх мэдээлэл, Барилгын салбарын ХАБ-ын сургалтын зарыг байрлуулав.



Суурь судалгаа, газрын мониторингийн асуудал хариуцсан мэргэжилтний компьютерт хэвлэгчийг таниулж өгөв.



Мэдээлэл:

70376471 нээлттэй утсаар 26 иргэн, ААНБ-ын асуусан асуултанд хариулсан. Дархан-Уул аймгийн Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын Facebook хуудсанд иргэнээс асуусан 8 асуултанд хариулсан.

Darkhan.gov.mn цахим хуудасны мэдээллийг шинэчлэх ажилд зориулан байгууллагын холбоо барих утасны мэдээллийг шинэчлэн Абле чатаар илгээв.

Нярав:



20 ширхэг Нэгж талбарын хувийн хэргийн хавтас нугалж, мэргэжилтнүүдэд олгоход бэлтгэв. Газрын удирдлагын хэлтсийн мэргэжилтнүүдэд 25 ширхэг нэгж талбарын хувийн хэргийн хавтас олгов.

Шаардах хуудсаар 8 төрлийн 711 ширхэг бараа материал олгов. 1-р сарын нэгж талбарын хувийн хэргийн хавтас, бараа материалын зарцуулалтын тайланг нэгтгэж ня-бод өгөв.

Архив, бичиг хэрэг:

Иргэдээс ирүүлсэн өргөдөл 4 ширхэг, ААНБ-уудаас ирсэн албан бичиг 37 ширхэгийг албан хэрэг хөтлөлтийн Able системд бүртгэж байгууллагын даргаар цохуулан мэргэжилтнүүдэд тарааж өгөв. Байгууллагын мэргэжилтнүүдийн шийдвэрлэсэн өргөдөл 1 ширхэг, албан бичиг 19 ширхэгийг албан хэрэг хөтлөлтийн Able системд шийдвэрлэгдсэнээр бүртгэн хааж, хураав.

Байгууллагаас бусад байгууллага болон иргэдэд илгээж буй албан бичиг 17 ширхэгийг бланкан дээр буулгаж, илгээв. Байгууллагын даргын тушаал 2 ширхэгийг бланкан дээр буулгав.

Архиваас 7 ширхэг материал гаргаж өгч үзсэний дараа буцааж архивт хураав.

ЗАХИРГАА, ХУУЛИЙН АСУУДАЛ

ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН

Б.ЗОЛБАЯСАХ

ХЯНАСАН:

ГАЗРЫН УДИРДЛАГЫН

ХЭЛТСИЙН ДАРГА

Г.НЯМДОРЖ